

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал.....	12
3.1	Зардлын данстай холбоотой асуудал.....	12
3.2	Балансын данстай холбоотой асуудал.....	12
3.3	Балансын данстай холбоотой асуудал.....	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6	Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	22
5	Хавсралт.....	23
5.1	Аудитын явцад илрүүлсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Г.ӨНӨРБАЯР ТАНАА

2019.02.25 № 06/305
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 25-наас 2019 оны 2 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Энхдалай хариуцаж хэрэгжүүлэв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 3/305 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын харилцан хамаарал бүхий цогц бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангахад оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 3 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт” тус яамны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, энэ чиглэлээр салбар хоорондын зохицуулалт хийх;
- Цалин хөлс, хөдөлмөрийн харилцааны оновчтой тогтолцоо, хөдөлмөрлөх таатай орчныг бүрдүүлэх;

- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурласан мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, ажиллах хүчний зохистой нөөцийг бий болгох, ажиллах хүчний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх;
- Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлж, хүн амын хөгжлийг хангах нийгмийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн нийгмийн цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүн амын насны бүтцийн хэтийн төлөвийг харгалзан хүн амын бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх замаар хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах;
- Салбарын хүний нөөц, удирдлагын чадавх, зохион байгуулалтыг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль
- Ахмад настны тухай хууль
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Гүүк софт ХХК-ийн "Axplorer" програм хангамж ашигладаг байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 17 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2018 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Яамны үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратегийн мөн чанар нь үйлчлүүлэгч, хэрэглэгчдийн хэрэгцээг мэргэжлийн өндөр түвшинд, шуурхай хангах, бүх талын дэмжлэг үзүүлэх, бодлогын зөвлөгөө, зөвлөмжөөр хангахад чигэлдэг байдлыг харгалзан үзэж нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонголоо. Үйл ажиллагааны болон, санхүүгийн тайлан, балансын дансанд хийсэн эрсдэлийн үнэлгээг харгалзан материаллаг байдлын түвшинг 2 хувиар тооцсон.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны нийт зардал 77,610,057.3 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 1,552,201.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 15 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 8 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчил биш гэж үзлээ. Санхүүгийн тайлан илэрсэн 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 493,245.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 19,700.0 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 442,116.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 31,428.9 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй анхаарч ажиллах зөвлөмж өгсөн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	/мянган төгрөгөөр/	
			Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	31,428.9	
2	Албан шаардлага өгсөн	3	442,026.5	
	Дүн	6	473,545.5	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Дотоод хяналттай холбоотой асуудал

Төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлсэн гэрээт ажлын гүйцэтгэлийн 339,934.4 мянган төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно."* заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.

2.8.1.2 Балансын данстай холбоотой асуудал

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 743.8 мянган төгрөгийн ном, 73,143.4 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг тоолж баталгаажуулаагүй нь тохиолдсон байх, оршин байх батламж мэдэгдэлүүдтэй нийцэхгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 70 дугаар зүйлийн 70.2.1, 70.2.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.

2.8.1.3 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйл ажиллагааны зардлаас салбарын уралдаан тэмцээн зохион байгуулах арга хэмжээний зардал, спортын хувцасны үнэ, ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний төлбөрт нийт 28,295.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь үнэн зөв, байдал батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.5 *"Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,"* заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт" ажилладаг боловч төрийн бус байгууллага, хувь хүмүүстэй гэрээ байгуулан судалгаа, шинжилгээний ажил хийлгэж байгаа нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах ажил хангалтгүй байгаад анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 16 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 74,913,464.8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 73,207,200.5 мянган төгрөг буюу 97.7 хувьтай гүйцэтгэлтэй байгаа нь Япон улсад шинээр нээж үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв үйл ажиллагаа явуулаагүйгээс зарцуулагдаагүй 1,706,264.4 мянган төгрөгийн үлдэгдэлийг Сангийн яаманд төвлөрүүлсэн байна.

Мөн Засгийн газрын нөөц сан, Нэгдсэн үндэсний байгууллагын, “Хүн амын сан”, Азийн хөгжлийн банк, Швейцарийн хөгжлийн агентлаг, Германы хамтын ажиллагааны байгууллага, Хүнс тэжээл нийгмийн халамж төслийн нэмэлт санхүүжилт, Олон улсын хөдөлмөрийн байгууллага зэрэг 11 байгууллагаас төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хандив тусламж нийт 1,007,488.6 мянган төгрөгийг авч 935,625.9 мянган төгрөгийг зарцуулж үлдсэн 71,862.7 мянган төгрөгийг Сангийн яаманд төвлөрүүлэн санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүргийн дагуу 2018 оны төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээг тухай бүр нь цахим хуудсанд мэдээллэсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100.0 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд нөлөөлж болзошгүй анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

1. Илрүүлэлт:

Бэлтгэн нийлүүлэгч 12 байгууллагаас худалдан авсан 24,530.1 мянган төгрөгийн хөрөнгийг шууд зардлаар бүртгэсэн нь үнэн, зөв байдал толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлүүд болон Сангийн сайдын 388 тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

2. Эрсдэл:

Хөрөнгө, зардлыг буруу ангилан бүртгэсэн байх;

3. Өгсөн зөвлөмж:

Ажил гүйлгээг зөв ангилан бүртгэх холбогдох заавар, журмыг мөрдөж ажиллах;

3.2 Балансын данстай холбоотой асуудал

1. Илрүүлэлт:

Үндэсний тогтмол хэвлэлүүдийн холбооноос авах 3,920.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нь тохиолдсон байх, оршин байх батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 дахь “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж,

үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалтыг зөрчсөн байна.

2. Эрсдэл:

Эд хөрөнгийн тооллогыг хийгээгүй байх;

3. Өгсөн зөвлөмж:

Эд хөрөнгийн тооллогыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх, холбогдох заавар, журмыг мөрдөж ажиллах;

3.3 Балансын данстай холбоотой асуудал

1. Илрүүлэлт:

Шатахууны 2,978.8 мянган төгрөгийн зарцуулалтын тайлангүй, шууд зардлаар бүртгэсэн нь иж бүрэн байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлтэй нийцээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтыг зөрчсөн байна.

2. Эрсдэл:

Хөрөнгө, зардлыг буруу ангилан бүртгэсэн байх; Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан байх;

3. Өгсөн зөвлөмж:

Шатахууныг бараа материалын тайланд бүртгэж, зарцуулалтын тайланг гаргаж байх, холбогдох заавар, журмыг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	157,925,083.48	190,496,400.24
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,701.04	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,701.04	-
3121	Төгрөг	2,701.04	-
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	2,701.04	
33	АВЛАГА	91,511,412.67	97,864,945.47
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	7,868,226.69	12,182,243.50
33300	Татаас, санхүүжилтийн авлага	36,564,262.98	71,862,701.97
335	Бусад авлага	47,078,923.00	13,820,000.00
3351	Байгууллагаас авах авлага	38,906,923.00	13,820,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	60,558,614.77	92,631,454.77
354	Хангамжийн материал	60,558,614.77	92,631,454.77
35410	Бичиг хэргийн материал	3,386,506.30	35,151,046.30
35420	Аж ахуйн материал	42,139,208.47	42,328,708.47
35440	Түлш, шатах тослох материал	2,267,400.00	2,582,400.00
35470	Бусад хангамжийн материал	12,765,500.00	12,569,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,265,613,791.84	7,661,719,011.02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,265,613,791.84	7,661,719,011.02
392	Биет хөрөнгө	5,258,820,091.96	5,479,845,933.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,860,926,620.00	3,728,716,115.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,598,917,676.63)	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	385,368,000.00	200,698,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(203,579,299.59)	(116,215,988.55)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,102,070,256.85	2,185,460,796.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	(716,024,093.93)	(894,871,698.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	585,854,310.55	578,898,001.55
39208	Хуримтлагдсан элэгдэл	(230,765,199.29)	(276,726,467.10)
39214	Бусад үндсэн хөрөнгө	73,143,374.00	73,143,374.00
39217	Ном	743,800.00	743,800.00
393	Биет бус хөрөнгө	6,793,699.88	2,181,873,077.54
39301	Програм хангамж	55,313,161.00	2,198,613,661.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(48,519,461.12)	(50,836,723.46)
39303	Бусад биет бус хөрөнгө		34,096,140.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,423,538,875.32	7,852,215,411.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	51,652,246.62	1,982,991.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	51,652,246.62	1,982,991.00
413	Өглөг	51,652,246.62	1,982,991.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	244,430.00	9,091.00
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	652,800.00	1,973,900.00
4136	Бусад өглөг	50,755,016.62	-
41361	Байгууллагад төлөх өглөг	50,755,016.62	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,371,886,628.70	7,850,232,420.26
51	Засгийн газрын хувь оролцоо	5,371,886,628.70	7,850,232,420.26
51101	Өмч: - төрийн		34,096,140.00
512	Хуримтлагдсан үр дүн	5,371,886,628.70	7,369,066,882.30
51210	Өмнөх үеийн үр дүн	5,371,886,628.70	5,787,503,599.14
51220	Тайлант үеийн үр дүн		1,581,563,283.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		447,069,397.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,423,538,875.32	7,852,215,411.26

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	64,339,955,325.47	79,191,620,603.65
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	265,787,789.25	3,283,352,835.62
120	Нийтлэг татварын бус орлого	265,787,789.25	3,283,352,835.62
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	265,787,789.25	3,283,352,835.62
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	329,000.00	2,070,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	265,458,789.25	3,281,282,635.62
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	64,074,167,536.22	75,908,267,768.03
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	62,120,463,400.00	74,831,113,774.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	62,120,463,400.00	74,831,113,774.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,953,704,136.22	1,077,153,994.03
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,690,769,831.22	967,153,994.03
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	262,934,305.00	100,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		10,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	65,742,754,733.07	76,425,151,382.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,742,754,733.07	76,425,151,382.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,196,235,803.29	7,003,581,679.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,063,312,918.59	1,772,197,996.00
210101	Үндсэн цалин	1,647,465,897.59	1,772,197,996.00
210102	Нэмэгдэл	251,321,521.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	164,525,500.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	187,322,064.42	220,250,784.01
210201	Тэтгэврийн даатгал	120,792,016.63	149,549,381.98
210202	Тэтгэмжийн даатгал	13,355,161.56	14,250,585.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,617,151.95	17,640,880.08
210204	Ажилгүйдлийн даатгал	3,323,430.39	3,528,176.02
210205	Эрүүл мэндийн даатгал	33,234,303.89	35,281,760.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	185,766,200.00	197,651,728.00
210301	Гэрэл, цахилгаан	77,585,200.00	82,183,900.00
210302	Түлш, халаалт	74,794,400.00	74,794,400.00
210303	Цэвэр, бохир ус	24,646,600.00	24,646,600.00
210304	Байрны түрээс	8,740,000.00	16,026,828.00
2104	Хангамж, бараа материалын зардал	276,732,459.81	245,105,566.48
210401	Бичиг хэрэг	166,525,632.18	170,412,596.00
210402	Тээвэр, шатахуун	24,649,060.00	20,775,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,612,610.63	39,440,242.48
210404	Ном, хэвлэл		27,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	51,945,157.00	14,450,728.00
2105	Нормативт зардал	101,016,999.27	199,344,427.00
210502	Хоол, хүнс	101,016,999.27	199,344,427.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,482,300.00	7,981,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,363,300.00	

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	8,119,000.00	7,981,000.00
2107	Томилолт, зочны зардал	224,250,084.00	181,590,835.32
210701	Гадаад албан томилолт	30,371,000.00	
210702	Дотоод албан томилолт	193,879,084.00	181,590,835.32
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,473,587,169.00	3,090,501,636.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,461,502,337.00	3,073,595,030.90
210803	Даатгалын үйлчилгээ	6,041,168.00	9,480,210.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,149,700.00	426,532.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	277,200.00	109,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,269,900.00	6,444,000.00
210807	Газрын төлбөр	1,346,864.00	446,864.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,672,765,608.20	1,088,957,706.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	461,190,132.00	287,939,908.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	637,964,564.37	254,305,995.14
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	573,610,911.83	546,711,803.08
212	ТАТААС	497,038,200.00	497,038,200.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	497,038,200.00	497,038,200.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	497,038,200.00	497,038,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,049,480,729.78	68,924,531,502.24
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	58,021,967,101.90	67,224,269,485.90
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	57,850,352,771.90	67,074,650,488.02
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	171,614,330.00	149,618,997.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,265,855.00	25,469,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,265,855.00	25,469,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,247,772.88	1,674,792,216.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,247,772.88	1,674,792,216.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,402,799,407.60)	2,766,469,221.48
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	189,482,773.03	1,184,905,938.32
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	189,482,773.03	1,184,493,105.32
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз		412,833.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(189,482,773.03)	(1,184,905,938.32)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,592,282,180.63)	1,581,563,283.16

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>64,154,497,856.84</u>	<u>75,974,721,321.01</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	329,000.00	2,070,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	329,000.00	2,070,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	329,000.00	2,070,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	329,000.00	2,070,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	64,154,168,856.84	75,972,651,121.01
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	62,120,463,400.00	74,831,113,774.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	62,120,463,400.00	74,831,113,774.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,033,705,456.84	1,141,537,347.01
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,770,771,151.84	1,031,537,347.01
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	262,934,305.00	100,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		10,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>64,147,082,665.80</u>	<u>75,974,724,022.05</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,147,082,665.80	75,974,724,022.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,529,499,473.04	6,481,291,617.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,909,550,304.00	1,643,480,209.00
210101	Үндсэн цалин	1,491,131,804.00	1,171,884,209.00
210102	Нэмэгдэл	324,571,500.00	326,797,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	93,847,000.00	144,798,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	165,600,900.00	195,302,900.00
210201	Тэтгэврийн даатгал	165,600,900.00	134,418,100.00
210202	Тэтгэмжийн даатгал		15,221,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		12,177,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал		3,044,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал		30,442,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	227,791,588.59	197,651,728.00
210301	Гэрэл, цахилгаан	77,585,200.00	82,183,900.00
210302	Түлш, халаалт	116,819,788.59	74,794,400.00
210303	Цэвэр, бохир ус	24,646,600.00	24,646,600.00
210304	Байрны түрээс	8,740,000.00	16,026,828.00
2104	Хангамж, бараа материалын зардал	240,717,649.81	222,564,906.48
210401	Бичиг хэрэг	171,058,282.18	145,644,536.00
210402	Тээвэр, шатахуун	20,168,460.00	21,090,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,612,610.63	39,440,242.48
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,878,297.00	16,390,128.00
2105	Нормативт зардал	101,016,999.27	199,344,427.00
210502	Хоол, хүнс	101,016,999.27	199,344,427.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,482,300.00	7,981,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,363,300.00	
210604	Урсгал засвар	8,119,000.00	7,981,000.00
2107	Томилолт, зочны зардал	224,250,084.00	181,590,835.32
210701	Гадаад албан томилолт	30,371,000.00	
210702	Дотоод албан томилолт	193,879,084.00	181,590,835.32

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,483,164,724.00	3,291,129,708.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,464,855,737.00	3,273,402,502.90
210803	Даатгалын үйлчилгээ	10,188,523.00	9,480,210.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,149,700.00	426,532.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	277,200.00	109,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,346,700.00	7,264,600.00
210807	Газрын төлбөр	1,346,864.00	446,864.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,165,924,923.37	542,245,903.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	462,030,132.00	287,939,908.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	703,894,791.37	254,305,995.14
212	ТАТААС	497,038,200.00	497,038,200.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	497,038,200.00	497,038,200.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	497,038,200.00	497,038,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,120,544,992.76	68,996,394,204.21
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	58,021,967,101.90	67,224,269,485.90
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	57,850,352,771.90	67,074,650,488.02
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	171,614,330.00	149,618,997.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,765,855.00	25,469,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,265,855.00	25,469,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,500,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,247,772.88	1,746,654,918.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,247,772.88	1,746,654,918.31
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,564,262.98	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,564,262.98	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	7,415,191.04	(2,701.04)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,412,490.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,412,490.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	7,412,490.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,412,490.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(7,412,490.00)	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,701.04	(2,701.04)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,701.04
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,701.04	

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			5,371,886,628.70		5,371,886,628.70
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	5,371,886,628.70	0.00	5,371,886,628.70
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	5,371,886,628.70	0.00	5,371,886,628.70
D01	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	5,371,886,628.70	0.00	5,371,886,628.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			415,616,970.44		415,616,970.44
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	5,787,503,599.14	0.00	5,787,503,599.14
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		447,069,397.96			447,069,397.96
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	34,096,140.00				34,096,140.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			1,581,563,283.16		1,581,563,283.16
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,096,140.00	447,069,397.96	7,369,066,882.30	0.00	7,850,232,420.26

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	74,913,464,900.00	73,207,200,474.28	1,706,264,425.72	97.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	74,913,464,900.00	73,207,200,474.28	1,706,264,425.72	97.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,144,656,500.00	5,460,422,988.38	1,684,233,511.62	76.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,832,960,300.00	1,633,480,209.00	199,480,091.00	89.1
210101	Үндсэн цалин	1,162,055,100.00	1,161,884,209.00	170,891.00	100
210102	Нэмэгдэл	526,106,700.00	326,797,500.00	199,309,200.00	62.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	144,798,500.00	144,798,500.00	-	100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	205,619,200.00	195,302,900.00	10,316,300.00	95
210201	Тэтгэврийн даатгал	144,734,400.00	134,418,100.00	10,316,300.00	92.9
210202	Тэтгэмжийн даатгал	15,221,200.00	15,221,200.00	-	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,177,000.00	12,177,000.00	-	100
210204	Ажилгүйдлийн даатгал	3,044,200.00	3,044,200.00	-	100
210205	Эрүүл мэндийн даатгал	30,442,400.00	30,442,400.00	-	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	999,859,900.00	181,624,900.00	818,235,000.00	18.2
210301	Гэрэл, цахилгаан	82,183,900.00	82,183,900.00	-	100
210302	Түлш, халаалт	74,794,400.00	74,794,400.00	-	100
210303	Цэвэр, бохир ус	24,646,600.00	24,646,600.00	-	100
2104	Хангамж, бараа материалын зардал	128,027,800.00	101,646,770.48	26,381,029.52	79.4
210401	Бичиг хэрэг	28,104,300.00	25,375,400.00	2,728,900.00	90.3
210402	Тээвэр, шатахуун	32,595,400.00	21,090,000.00	11,505,400.00	64.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	47,906,100.00	38,791,242.48	9,114,857.52	81
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,015,000.00	16,390,128.00	2,624,872.00	86.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,119,000.00	7,981,000.00	6,138,000.00	56.5
210604	Урсгал засвар	8,119,000.00	7,981,000.00	138,000.00	98.3
2107	Томилолт, зочны зардал	52,257,500.00	49,257,500.00	3,000,000.00	94.3
210702	Дотоод албан томилолт	52,257,500.00	49,257,500.00	3,000,000.00	94.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,901,812,800.00	3,291,129,708.90	610,683,091.10	84.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,828,061,900.00	3,273,402,502.90	554,659,397.10	85.5
210803	Даатгалын үйлчилгээ	50,189,200.00	9,480,210.00	40,708,990.00	18.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	6,149,700.00	426,532.00	5,723,168.00	6.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	277,200.00	109,000.00	168,200.00	39.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,852,800.00	7,264,600.00	2,588,200.00	73.7
210807	Газрын төлбөр	1,782,000.00	446,864.00	1,335,136.00	25.1

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

212	ТАТААС	497,038,200.00	497,038,200.00	-	100
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	497,038,200.00	497,038,200.00	-	100
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	497,038,200.00	497,038,200.00	-	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,271,770,200.00	67,249,739,285.90	22,030,914.10	100
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	67,246,300,400.00	67,224,269,485.90	22,030,914.10	100
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	67,074,684,000.00	67,074,650,488.02	33,511.98	100
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	171,616,400.00	149,618,997.88	21,997,402.12	87.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,469,800.00	25,469,800.00	-	100
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,469,800.00	25,469,800.00	-	100
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0		

4.6 Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		2.701.04	
13	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		10,000,000.00	(10,000,000.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		10,000,000.00	(10,000,000.00)
131105	Төсвийн байгуулгын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		10,000,000.00	(10,000,000.00)
70202	Санхүү, төсөв, эдийн засгийн нэгдсэн удирдлага		100,000,000.00	(100,000,000.00)
81101	Засгийн газрын нөөц хөрөнгө		100,000,000.00	(100,000,000.00)
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		100,000,000.00	(100,000,000.00)
21	Урсгал зардал		100,000,000.00	(100,000,000.00)
210	Бараа ажил үйлчилгээний зардал		100,000,000.00	(100,000,000.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		100,000,000.00	(100,000,000.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		100,000,000.00	(100,000,000.00)
13	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		100,000,000.00	(100,000,000.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		100,000,000.00	(100,000,000.00)
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан		100,000,000.00	(100,000,000.00)
71903	Нийгмийн хамгааллын бодлого удирдлага		1,041,540,048.05	(1,041,540,048.05)
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал		1,041,540,048.05	(1,041,540,048.05)
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		1,041,540,048.05	(1,041,540,048.05)
21	Урсгал зардал		920,868,629.49	(920,868,629.49)
210	Бараа ажил үйлчилгээний зардал		920,868,629.49	(920,868,629.49)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		10,000,000.00	(10,000,000.00)
210101	Үндсэн цалин		10,000,000.00	(10,000,000.00)
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		16,026,828.00	(16,026,828.00)
210304	Байрны түрээс		16,026,828.00	(16,026,828.00)
2104	Хангамж, бараа материалын зардал		120,918,136.00	(120,918,136.00)
210401	Бичиг хэрэг		120,269,136.00	(120,269,136.00)
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр		649,000.00	(649,000.00)
2105	Норматив зардал		199,344,427.00	(199,344,427.00)
210502	Хоол хүнс		199,344,427.00	(199,344,427.00)
2107	Томилолт, зочны зардал		132,333,335.32	(132,333,335.32)
210702	Дотоод албан томилолт		132,333,335.32	(132,333,335.32)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		442,245,903.14	(442,245,903.14)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		187,939,908.00	(187,939,908.00)
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		254,305,995.14	(254,305,995.14)
26	Төвлөрүүлэх үйлдвэрлэлийн дадлага хийх		120,671,418.59	(120,671,418.59)
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		120,671,418.59	(120,671,418.59)
13	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		1,031,537,347.01	(1,031,537,347.01)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,031,537,347.01	(1,031,537,347.01)
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан		1,031,537,347.01	(1,031,537,347.01)
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	

5 Хавсралт

5.1 Аудитын явцад илрүүлсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Огноо:	Аудитын нэр:	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудит	Аудитын код:
2019/2/22			САГ-2019/294/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын	Хөдөлмөр, нийгмийн		мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл		Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Албан тушаал	Овог нэр
A	3	4	5		9	10
1	Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 743.8 мянган төгрөгийн ном, 73,143.4 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг тоолж баталгаажуулаагүй.	73,887.2	Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.	2/22/2019	Төрийн нарийн бичгийн дарга: СҮАХ мэргэжилтэн:	Г.Өнөрбаяр Л.Сансартуяа
2	12 байгууллагаас худалдан авсан 24,530.1 мянган төгрөгийн хөрөнгийг шууд зардлаар бүртгэсэн.	24,530.1	Зөвлөмж өгөх.	2/22/2019	Төрийн нарийн бичгийн дарга: СҮАХ мэргэжилтэн:	Г.Өнөрбаяр Л.Сансартуяа
3	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйл ажиллагааны зардлаас 28,295.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.	28,295.0	Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.	2/22/2019	Төрийн нарийн бичгийн дарга: СҮАХ мэргэжилтэн:	Г.Өнөрбаяр Л.Сансартуяа
4	Шатахууны зарцуулалтын тайлангүй, шууд зардлаар бүртгэсэн.	2,978.8	Зөвлөмж өгөх.	2/22/2019	Төрийн нарийн бичгийн дарга: СҮАХ мэргэжилтэн:	Г.Өнөрбаяр Л.Сансартуяа
5	Үндэсний тогтмол хэвлэлүүдийн холбооноос авах 3,920.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй.	3,920.0	Зөвлөмж өгөх.	2/22/2019	Төрийн нарийн бичгийн дарга: СҮАХ мэргэжилтэн:	Г.Өнөрбаяр Л.Сансартуяа
6	Төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлсэн гэрээт ажлын 339,934.4 мянган төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан.	339,934.4	Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.	2/22/2019	Төрийн нарийн бичгийн дарга: СҮАХ мэргэжилтэн:	Г.Өнөрбаяр Л.Сансартуяа